



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/04

Дэлгэрхаан сум

Хөрөнгө данс бүртгэлд бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 30-ны 33 дугаар албан бичгийн дагуу Монгол Улсын Засгийн газраас олгосон туулах чадвар сайтай Mitsubishi L200 маркийн 155,000,000 (нэг зуун тавин таван сая) төгрөгийн өртөгтэй автомашиныг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэсүгэй.

2. Автомашины засвар үйлчилгээг тогтмол хийж зөвхөн албан хэрэгцээнд ашиглахыг жолооч (Ч.Адъяахүү)-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийг хууль тогтоомж, журманд нийцүүлэн бүртгэх ажлыг зохион байгуулахыг нягтлан бодогч (О.Анхцэцэг), нярав (Л.Баатархүү) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.УРАНГОО



2325029008

